



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/523

Номгон

Г  
"Сургалтын чанар-Багшийн хөгжлөөс" нэгдсэн  
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр (2021-2024)-ийн 2.3.1, аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний 48 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Чадварлаг багш арга хэмжээний төлөвлөгөөг (2021-2024 он) хэрэгжүүлэх, багшийн бүтээлч ур чадварыг дээшлүүлэх, улсын төрөлжсөн хичээлүүдийн олимпиад, элсэлтийн шалгалт, багшийн гүйцэтгэлийн үнэлгээг ахиулах зорилгоор "Сургалтын чанар-Багшийн хөгжлөөс" нэгдсэн арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 04-06-нд Баянхонгор сумд зохион байгуулсугай.

2.Арга хэмжээний нэгдсэн удирдамж, хөтөлбөрийг боловсруулж, сайтар зохион байгуулж, тайлагнахыг Боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Алтанцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Арга хэмжээний зардал болох 21.500.000 (Хорин нэгэн сая таван зуун мянга) төгрөгийг хавсралтад зааснаар баталж, аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа) -д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (В.Наранчимэг)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

624211351

Аймгийн Засаг даргын \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар  
сарын \_\_\_\_\_ ны өдрийн \_\_\_\_\_ дугаар  
захирамжийн хэвсрэлт

"СУРГАЛТЫН ЧАНАР-БАГШИЙН ХӨГЖЛӨӨС" НЭГДСЭН  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

№	Зардлын нэр төрөл	Хэмжих нэгж	Оролцох хүний тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	2	3	4	5	6
1	Сургалт, арга хэмжээнд оролцогчдын цайны зардал	Хүн	1000	5000	5.000.000
2	Сургалт арга хэмжээнд оролцогчдын хоолны зардал	Хүн	1000	12.000	12.000.000
3	Сургалт, арга хэмжээний бичиг хэргийн зардал	Хүн	1000	4500	4.500.000
	Бүгд	Хорин нэгэн сая, таван зуун мянган төгрөг			21.500.000

оОо